



## ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	2
1.1. Зорилго .....	2
1.2. Хамрах хүрээ .....	2
1.3. Хүчин төгөлдөр болох .....	2
1.4. Нэр томъёо.....	2
1.5. Гишүүнчлэл.....	2
1.6. Гишүүнчлэлийн гэрээ .....	2
ХОЁР. ГИШҮҮН ҮЦК-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	3
2.1. Ерөнхий шаардлага.....	3
2.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хязгаар.....	3
2.3. Гишүүн ҮЦК-ийн техникийн шаардлага .....	3
ГУРАВ. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ.....	4
3.1. Гишүүнээр элсэх өргөдөл ирүүлэх .....	4
3.2. Өргөдөлд хавсаргах бичиг баримт .....	4
3.3. Нэмэлт мэдээлэл шаардах .....	4
3.4. Гишүүнээр элсүүлэх шийдвэр.....	5
ДӨРӨВ. ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХУРААМЖ .....	7
4.1. Ерөнхий зүйл .....	7
4.2. Хураамж.....	7
ТАВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ .....	8
5.1. Гишүүн ҮЦК-д тавих хяналт .....	8
5.2. Гишүүн ҮЦК-д хийх шалгалт .....	8
ЗУРГАА. ГИШҮҮН ҮЦК-ИЙН ЭРХ ДУУСГАВАР БОЛОХ .....	9
6.1. Гишүүнчлэлийн гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдэх.....	9
6.2. Гишүүнчлэлийн гэрээг цуцлах .....	9
6.3. Гишүүн ҮЦК-ийн хүсэлтээр Гишүүнчлэлийн гэрээг цуцлах .....	9
Хавсралт 1. Маягт 1 .....	10
Маягт 2 .....	11
Маягт 3 .....	12
Маягт 4 .....	13
ХАВСРАЛТ 2. Гишүүнчлэлийн гэрээний үлгэрчилсэн загвар.....	14

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1. Зорилго

- (1) Энэ журмын зорилго нь “Монголын Үнэт Цаасны Бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-ийн гишүүнээр элсэхээр хүсэлт гаргасан компанийг Биржийн гишүүн (цаашид “Гишүүн ҮЦК” гэх)-ээр элсүүлэх, хяналт тавих, гишүүнээс хасах болон Биржтэй хамтран ажиллах бүхий л харилцааг зохицуулахад оршино.

### 1.2. Хамрах хүрээ

- (1) Гишүүн ҮЦК нь энэ журмаас гадна Биржээс баталсан журам, шийдвэрийг дагаж мөрдөнө.

### 1.3. Хүчин төгөлдөр болох

- (1) Энэ журам, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн тогтоолыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) батламжилна.
- (2) Хороо өөрөөр шийдвэрлээгүй бол энэ журам нь ТУЗ-ийн тогтоолд заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд журмыг мөрдөж эхлэхээс хуанлийн гуч (30)-аас доошгүй хоногийн өмнө Биржийн цахим хуудаст нийтлэн нийтэд танилцуулна.
- (3) Энэ журамтай нийцүүлэн гаргах албаны журам болон бусад бичиг баримтуудыг Биржийн Гүйцэтгэх удирдлага батална.
- (4) Энэхүү журмын хавсралтууд журмын салшгүй хэсэг байна.

### 1.4. Нэр томьёо

- (1) Энэхүү журамд орсон нэр томьёог Монгол Улсын хууль тогтоомж, Хороо болон Биржийн бусад журмуудад тайлбарласан утгаар ойлгоно.

### 1.5. Гишүүнчлэл

- (1) Гишүүн ҮЦК нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангасан, Биржтэй Гишүүнчлэлийн гэрээ байгуулсан хуулийн этгээд байна.
- (2) Гишүүн ҮЦК нь дараах төрлийн үйл ажиллагааг дангаар болон хавсран гүйцэтгэж болно. Үүнд:
  - (i) Брокер;
  - (ii) Дилер;
  - (iii) Андеррайтер;
  - (iv) Зах зээл үүсгэгч.
- (3) Энэ журмын 1.5(2)-т заасан Гишүүн ҮЦК-ийн үйл ажиллагааг Арилжааны журамд нарийвчлан тусгана.

### 1.6. Гишүүнчлэлийн гэрээ

- (1) Гишүүн ҮЦК-ийн Биржтэй хамтран ажиллах үйл ажиллагааны төрөл, түүнтэй холбоотой үүсэх харилцааг Хавсралт 2-т заасан “Гишүүнчлэлийн гэрээ”-гээр зохицуулна.

## **ХОЁР. ГИШҮҮН ҮЦК-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА**

### **2.1. Ерөнхий шаардлага**

- (1) Гишүүн ҮЦК нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, улсын бүртгэл, татвар, нийгмийн даатгалын болон бусад эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн, эдгээр бүртгэлүүдтэй холбоотой аливаа зөрчилгүй байна.
- (2) Гишүүн ҮЦК нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам”-ын дагуу тухайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий этгээд байна.
- (3) Биржид гишүүнээр элсэх тухай хүсэлт гаргахаас өмнөх 1 (нэг) жилийн хугацаанд хүсэлт гаргагч этгээдийг татан буулгах, дампууруулах тухай аливаа хэрэг, маргаанд холбогдоогүй байна.
- (4) Гишүүн ҮЦК болон түүний толгой компани, эсхүл энгийн болон давуу эрхийн хувьцааны 5 (тав)-аас дээш хувийг эзэмшигч саналын эрхтэй этгээд нь Гишүүн ҮЦК-ийн үйл ажиллагаа, төлбөрийн чадварт ноцтой нөлөөлөхүйц хэмжээний хугацаа хэтэрсэн өргүй байна.
- (5) Гишүүн ҮЦК-ийн санхүү, эдийн засаг, эрх зүйн байдал нь харилцагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөргүй байна.
- (6) Гишүүн ҮЦК-ийн гүйцэтгэх удирдлага нь санхүүгийн зах зээл, түүнтэй ижил төрлийн салбарт ажиллаж байсан туршлагатай, сүүлийн 5 (таван) жилийн хугацаанд санхүүгийн зах зээлд холбогдолтой гэмт хэрэгт холбогдож байгаагүй этгээд байна.
- (7) Гишүүн ҮЦК нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх бүхий 5 (тав)-аас доошгүй ажилтантай байна.
- (8) Биржээс шаардсан тохиолдолд Гишүүн ҮЦК нь арилжаанд оролцох эрхээ тодорхой хугацаанд түдгэлзүүлсэн, гишүүний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн Гишүүн ҮЦК-ийн Гишүүнчлэлийн гэрээ болон энэ журамд заасан үүргийг бүхэлд нь болон хэсэгчлэн биелүүлэхийг зөвшөөрсөн 1 (нэг)-ээс доошгүй Гишүүн ҮЦК-тай эрх, үүрэг шилжүүлэх тухай гэрээ байгуулсан байна.

### **2.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хязгаар**

- (1) Гишүүн ҮЦК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь андеррайтер бол 1,000,000,000 (нэг тэрбум), дилер бол 200,000,000 (хоёр зуун сая), брокер бол 100,000,000 (нэг зуун сая) төгрөгөөс доошгүй байна.
- (2) Хэрэв гишүүн ҮЦК нь энэ журмын 1.5(2)-т заасан үйл ажиллагааг хавсарч гүйцэтгэдэг бол хавсарч гүйцэтгэж буй үйл ажиллагаанд тавигдах хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс доошгүй хөрөнгөтэй байна.

### **2.3. Гишүүн ҮЦК-ийн техникийн шаардлага**

- (1) Гишүүн ҮЦК Биржийн мэдээлэл технологи хариуцсан нэгжээс гаргасан шаардлагыг хангасан үзүүлэлт бүхий техник хэрэгсэл, программ хангамжийг ашиглах боломжтой байна.
- (2) Гишүүн ҮЦК нь Бирж болон Биржид сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллага хоорондын гэрээнд заасан техникийн нөхцөлийг бүрдүүлж, Биржийн арилжаа, төлбөр тооцооны системд сүлжээгээр холбогдох боломжтой байна.

## ГУРАВ. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ

### 3.1. Гишүүнээр элсэх өргөдөл ирүүлэх

- (1) Гишүүнээр элсэх хүсэлт гаргаж буй этгээд гишүүнээр элсэх тухай өргөдлийг энэ журмын Хавсралт 1-ийн дагуу бэлтгэж Биржид ирүүлнэ.
- (2) Бирж нь бүрдэл болон агуулгын аливаа зөрчилгүй баримт бичиг хүлээж авсан өдрийг баримт бичгийг албан ёсоор хүлээж авсан огноо гэж тооцно.
- (3) Биржид ирүүлсэн баримт бичигт нэмэлт өөрчлөлт орсон бол хүсэлт гаргагч нь энэ тухай ажлын 3 (гурван) өдрийн дотор Биржид мэдэгдэж, холбогдох баримт бичгийг ирүүлнэ.
- (4) Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гишүүнээр элсэхдээ холбогдох баримт бичгийг монгол хэл дээр орчуулж, баталгаажуулж ирүүлнэ.
- (5) Хүсэлт гаргагч этгээд нь Биржид хүлээлгэн өгч буй баримт бичгийн бүрдэл болон үнэн зөв байдлыг хариуцна.

### 3.2. Өргөдөлд хавсаргах бичиг баримт

Хүсэлт гаргагч нь дараах бичиг баримтыг өргөдөлд хавсаргана. Үүнд:

- (i) Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- (ii) Улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар, дүрэмд оруулсан боловч улсын бүртгэлд бүртгэгдээгүй байгаа нэмэлт өөрчлөлт;
- (iii) Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар;
- (iv) Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан сүүлийн нэг хүртэл жилийн санхүүгийн тайлан;
- (v) Компанийн үйл ажиллагааг зохицуулсан дотоод журам, харилцагчтай байгуулах гэрээний төсөл;
- (vi) Арилжаанд оролцох эрх авах, эсвэл эрх авсан ажилтны хувьд нууцлалын гэрээ байгуулсан талаар тодорхойлсон албан бичиг;
- (vii) Хувь нийлүүлэгч болон толгой, охин компанийн тухай мэдээлэл, энэхүү холбоо хамаарлыг нотлох холбогдох баримтуудын хуулбар;
- (viii) Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааны 5 (тав)-аас дээш хувийг эзэмшигч этгээд болон гүйцэтгэх удирдлагын анкет (маягт 2);
- (ix) Санхүүгийн баримт бичиг дээр гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- (x) Шаардлагатай гэж үзвэл энэ журмын 2.1(8)-д заасан гэрээний хуулбар.

### 3.3. Нэмэлт мэдээлэл шаардах

- (1) Бирж шаардлагатай гэж үзвэл энэ журамд заасан гишүүнээр элсэх хүсэлт гаргаж буй этгээдийн өргөдөл, түүний хавсралт баримт бичгийг нотлох нэмэлт баримт бичиг шаардаж болно.
- (2) Бирж нэмэлт мэдээлэл шаардсан бол энэ тухай хүсэлт гаргагч этгээдэд цахимаар эсвэл бичгээр мэдэгдэх ба хүсэлт гаргагч этгээд нэмэлт мэдээллийг албан бичигт заасан хугацаанд, хэрэв хугацаа заагаагүй бол ажлын 5 (таван) өдрийн дотор гаргаж өгнө.

- (3) Нэмэлт баримт бичиг ирүүлэхэд шаардлагатай хугацааг энэ журмын 3.4(2)-т заасан шийдвэр гаргах хугацаанд оруулж тооцохгүй.

#### **3.4. Гишүүнээр элсүүлэх шийдвэр**

- (1) ТУЗ энэ журамд заасан нөхцөл шаардлага, баримт бичгийн бүрдэл, агуулга болон Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгж, Гүйцэтгэх захирлын санал дүгнэлтийг үндэслэн гишүүнээр элсүүлэх тухай шийдвэр гаргана.
- (2) ТУЗ гишүүнээр элсэхээр хүсэлт гаргасан этгээдийн өргөдөл болон түүнд хавсаргах баримт бичгийг бүрэн хүлээж авснаас хойш ажлын 10 (арван) өдөрт багтаан гишүүнээр элсүүлэх тухай шийдвэр гаргана. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн даргын шийдвэрээр энэ журамд заасан хугацааг нэг удаа ажлын 10 (арван) өдөр хүртэл хугацаагаар сунгаж болно.
- (3) Гишүүнээр элсүүлэх шийдвэр гарсан тохиолдолд Бирж хүсэлт гаргасан этгээдэд ажлын 3 (гурван) өдрийн дотор мэдэгдэж, Гишүүнчлэлийн гэрээ байгуулна.
- (4) Биржийн гишүүнчлэл хариуцсан нэгж нь дараах нөхцөлд хүсэлт гаргагчийн өргөдөл, түүний хавсралт баримт бичгийг хангалтгүй гэж үзэн баримт бичгийг хүсэлт гаргагчид буцаан өгөх, эсхүл нэмэлт шаардлага хүргүүлж болно. Үүнд:
- (i) Энэ журамд заасан шаардлагыг хангаагүй бол;
  - (ii) Энэ журамд заасан баримт бичиг нь агуулга болон бүрдэлтийн хувьд зөрчилтэй, эсвэл Биржээс шаардсан өргөдөлтэй холбоотой мэдээллийг бүрэн ирүүлээгүй бол;
  - (iii) Хүсэлт гаргасан этгээд, түүний нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдсан, энэ тухай хүсэлт гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гарсан бол;
  - (iv) Хүсэлт гаргасан этгээд, түүний нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь тухайн компанийн үйл ажиллагаанд ноцтойгоор нөлөөлөхүйц хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох журмыг ноцтойгоор зөрчиж байсан, Хорооноос олгосон холбогдох тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон бол;
  - (v) Хүсэлт гаргасан этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эсхүл толгой компани нь сүүлийн 5 (таван) жилийн хугацаанд санхүүгийн гэмт хэрэгт холбогдон буруутай нь тогтоогдсон, эсхүл сэжиглэгдэн шалгагдаж байгаа бол;
  - (vi) Хүсэлт гаргасан этгээд Биржийн гишүүнээр элсэж, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх нь түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, толгой компанийн хувьд хуулиар хориглогдсон үйл ажиллагаа гэж үзсэн бол.
- (5) ТУЗ гишүүнээр элсүүлэхээс татгалзах шийдвэр гаргасан бол холбогдох шийдвэрийг үндэслэл бүхий тайлбарын хамт өргөдөл гаргагч этгээдэд бичгээр хүргүүлнэ.
- (6) Хүсэлт гаргасан этгээд гишүүнээр элсүүлэхээс татгалзах шийдвэр хүлээн авсан бол уг шийдвэрийн талаар гомдол гаргах, шийдвэр гарснаас хойш 6 (зургаан) сарын дотор гишүүнээр элсэх хүсэлтийг дахин гаргах эрхгүй.

- (7) Гишүүн ҮЦК бүрт Бирж гишүүний код олгоно. Энэ журамд өөрөөр заагаагүй бол Гишүүн ҮЦК өөрт олгосон кодыг бусдад ашиглуулах, дамжуулах, шилжүүлэхийг хориглоно.
- (8) Бирж шаардлагатай гэж үзвэл энэ журамд заасан гишүүнээр элсэх хүсэлт гаргаж буй этгээдийн өргөдөл, түүний хавсралт баримт бичгийг нотлох нэмэлт баримт бичиг шаардаж болно.

## **ДӨРӨВ. ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХУРААМЖ**

### **4.1. Ерөнхий зүйл**

- (1) Бирж Гишүүн ҮЦК-аас энэ журамд заасан үйлчилгээний хураамжийг авна. Элсэлтийн болон жилийн хураамж төлөх хугацаа, журмыг Бирж тогтооно.
- (2) Гишүүн ҮЦК энэ журмын 1.5(2)-т заасан үйл ажиллагааг хавсран гүйцэтгэж байгаа бол үйлчилгээний хураамжийг аль өндөр дүнтэй үйл ажиллагааны төрлөөр тооцно.

### **4.2. Хураамж**

- (1) Гишүүн ҮЦК элсэлтийн болон жилийн хураамжийг Биржид төлнө.
- (2) Гишүүн ҮЦК-ийн элсэлтийн хураамж 3,000,000 (гурван сая) төгрөг байна. Гишүүн ҮЦК-ийн элсэлтийн хураамжийг гишүүнээр элсүүлэх шийдвэр гарснаас хойш ажлын 5 (таван) өдрийн дотор төлнө.
- (3) Гишүүн ҮЦК-ийн жилийн хураамж 1,000,000 (нэг сая) төгрөг байна. Гишүүн ҮЦК нь жилийн хураамжийг тухайн жилийн эхний сард багтаан, эсхүл 4 (дөрөв) хуваан, улирал бүрийн эхний 10 (арван) өдөрт багтаан төлнө.
- (4) Шинээр элссэн Гишүүн ҮЦК нь түүнийг гишүүнээр элсүүлэх тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 1 (нэг) жилийн хугацаанд энэ журмын 4.2(3)-т заасан жилийн хураамжаас чөлөөлөгдөнө.
- (5) Арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлсэн нь Гишүүн ҮЦК-ийг жилийн хураамж төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

## **ТАВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ**

### **5.1. Гишүүн ҮЦК-д тавих хяналт**

- (1) Бирж гишүүн ҮЦК-д тавих хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:
  - (i) Гишүүн ҮЦК-ийн арилжаа, төлбөр тооцоотой холбоотой үйл ажиллагаа холбогдох хууль, журам, шийдвэрийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг арилжаа, төлбөр тооцооны системээр болон бусад холбогдох журмаар;
  - (ii) Энэ журам болон Гишүүнчлэлийн гэрээнд заасан Гишүүн ҮЦК-д тавигдах нөхцөл шаардлага, эрх үүргийн хэрэгжилт хангагдаж байгаа эсэхийг энэ журамд заасны дагуу шалгалт зохион байгуулж тус тус хянана.

### **5.2. Гишүүн ҮЦК-д хийх шалгалт**

- (1) Бирж шалгалт явуулах тухай шийдвэр гаргасан бол энэ тухай албан бичигт шалгалтын удирдамжийг хавсарган Гишүүн ҮЦК-д шалгалт эхлэхээс ажлын 3 (гурван) өдрийн өмнө хүргүүлнэ.
- (2) Шалгалтын удирдамжийг хууль тогтоомжийн дагуу боловсруулж, шалгалтын зорилго, хугацаа, хэлбэр, хамрах хүрээг тодорхой заасан байна.
- (3) Гишүүн ҮЦК-ийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэхийг хянах зорилгоор Бирж нь “Монголын Үнэт Цаасны Биржийн хяналтын журам” (цаашид “Хяналтын журам” гэх)-ын дагуу ээлжит шалгалт явуулна.
- (4) Бирж шаардлагатай гэж үзвэл ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр ээлжит бус шалгалтыг Гишүүн ҮЦК-д урьдчилан мэдэгдэлгүйгээр явуулж болно.
- (5) Бирж шалгалтын тайланг Гишүүн ҮЦК болон ТУЗ-д танилцуулна.
- (6) Гишүүн ҮЦК-уудад ногдуулах хариуцлагын арга хэмжээг Хяналтын журамд заасны дагуу авч хэрэгжүүлнэ.



## **ЗУРГАА. ГИШҮҮН ҮЦК-ИЙН ЭРХ ДУУСГАВАР БОЛОХ**

### **6.1. Гишүүнчлэлийн гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдэх**

- (1) Гишүүн ҮЦК-ийн гишүүнчлэлийн эрхийг дуусгавар болгох тухай ТУЗ-ийн шийдвэр нь Гишүүнчлэлийн гэрээг цуцлах үндэслэл болно.
- (2) Энэ журмаар Гишүүн ҮЦК-д тавигдах үндсэн шаардлагууд зөрчигдөх нөхцөл байдал үүссэн гэж үзвэл Бирж энэ тухай мэдэгдлийг Гишүүн ҮЦК-д нэн даруй хүргүүлнэ.
- (3) Гишүүн ҮЦК энэ журмын 6.1(2)-т заасан мэдэгдэлд өөрөөр заагаагүй бол мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор уг зөрчлийг арилгах үүрэгтэй бөгөөд энэ хугацаанд уг нөхцөл байдал, зөрчлийг арилгаагүй, энэ тухай холбогдох баримт бичиг, мэдээллийг ирүүлээгүй бол энэ нь Бирж Гишүүн ҮЦК-ийн гишүүнчлэлийн эрхийг дуусгавар болгох тухай шийдвэр гаргах үндэслэл болно.

### **6.2. Гишүүнчлэлийн гэрээг цуцлах**

- (1) Гишүүн ҮЦК-ийн Гишүүнчлэлийн гэрээнд зааснаас гадна дараах нөхцөл байдал үүссэн бол Гишүүнчлэлийн гэрээг цуцлах үндэслэл болно. Үүнд:
  - (i) Биржийн дүрэм, журам болон эрх бүхий этгээдийн шийдвэрийг биелүүлээгүй, эсвэл энэ журамд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн нөхцөл, шаардлагыг хангахгүй гэдэг нь тогтоогдсон;
  - (ii) Өөрийн санаачлагаар Гишүүнчлэлийн гэрээг цуцлах хүсэлт гаргасан;
  - (iii) Биржид Гишүүн ҮЦК-ийн эд хөрөнгийг битүүмжилсэн тухай албан ёсны мэдээлэл эрх бүхий байгууллагаас ирсэн;
  - (iv) Олон нийтийг төөрөгдүүлэх худал ташаа мэдээлэл тараасан, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг ноцтой хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал үүсгэсэн;
  - (v) Биржийн арилжаатай холбоотой аливаа шаардлагыг биелүүлээгүй;
  - (vi) Эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон;
  - (vii) Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу Гишүүн ҮЦК-д дампуурлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж эхэлсэн;
  - (viii) Гишүүнчлэлийн гэрээний хугацаа дуусгавар болсон.
- (2) Гишүүнчлэлийн гэрээг цуцлах нөхцөл үүссэн тухай мэдээлэл Биржид ирсэн бол уг мэдээллийг Биржийн гишүүнчлэлийн асуудал хариуцсан нэгж шалгаж, баталгаажуулсны үндсэн дээр харилцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Бирж тухайн Гишүүн ҮЦК-ийн арилжааны эрхийг нэн даруй түдгэлзүүлж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### **6.3. Гишүүн ҮЦК-ийн хүсэлтээр Гишүүнчлэлийн гэрээг цуцлах**

- (3) Гишүүн ҮЦК-ийн санаачлагаар Гишүүнчлэлийн гэрээг цуцлах өргөдлийг Бирж хүлээн авснаас хойш ажлын 10 (арван) өдрийн дотор шийдвэр гаргана.
- (4) Гишүүнчлэлийн гэрээг цуцлах өргөдөл гаргасан Гишүүн ҮЦК нь өргөдөл гаргасан өдрөөс хойш ажлын 20 (хорин) өдрийн хугацаанд гишүүний үүргээ бүрэн биелүүлэх үүрэгтэй бөгөөд энэ хугацаанд багтаан Бирж болон харилцагчтай бүх тооцоог дуусгасан байна.

## ХАВСРАЛТ 1

### Маягт 1

#### “Монголын Үнэт Цаасны Бирж”-д гишүүнээр элсэх хүсэлт гаргагчийн өргөдөл

Огноо:

Хэнд: “Монголын Үнэт Цаасны Бирж” ХК,  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Бээжингийн гудамж  
GB Plaza - 703 тоот

Хэнээс: “\_\_\_\_\_” \_\_\_\_\_ компани,

Бид өргөдлийн маягтад туссан мэдээ мэдээлэл, баримт бичгийг холбогдох хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Үнэт Цаасны Биржийн журам, зааврын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа мэдээлэл орсон тохиолдолд бид хариуцлагыг хүлээнэ.

Бид “Монголын Үнэт Цаасны Биржийн гишүүнчлэлийн журам”-ыг бүрэн хүлээн зөвшөөрч, энэхүү журмын хүрээнд үйл ажиллагаа явуулахаа илэрхийлж байна.

Түүнчлэн Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан Санхүүгийн зохицуулах хороо болон Биржийн бусад журам зааврыг мөрдөн ажиллах бөгөөд Биржээс тавьсан шаардлагыг ханган ажиллах болно.

Иймд энэхүү өргөдөл, холбогдох баримт бичгийг хянаж, Биржийн гишүүнээр элсэх зөвшөөрлийг олгоно уу.

Өргөдөл гаргагч:

Гүйцэтгэх захирал: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_

## Маягт 2

### “Монголын Үнэт Цаасны Бирж”-д гишүүнээр элсэх хүсэлт гаргагчийн мэдээлэл

“Монголын Үнэт Цаасны Бирж”-д гишүүнээр элсэхээр хүсэлт гаргагч нь энэхүү өргөдлийн маягтыг үнэн зөв бөглөж, холбогдох баримт бичгийн хамт Бирж (хаяг: GB плаза, Бээжингийн гудамж, 8 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, 703 тоот)-д шуудангаар, эсвэл биечлэн авчирч өгнө.


Өргөдөл гаргаснаас хойш хүсэлт гаргагчийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд өргөдлийн маягтыг үнэн зөв бөглөж, холбогдох баримтын хамт Биржид дахин ирүүлэх үүрэг хүлээнэ.

Компанийн ерөнхий мэдээлэл			
Компанийн нэр:		Байгуулагдсан он:	
Регистрийн дугаар:		Улсын бүртгэлийн дугаар:	
Хаяг (олон салбартай бол төв салбарын хаягийг бичнэ)			
Аймаг, нийслэл		Сум, дүүрэг	
Дэлгэрэнгүй			
Компанийн утас		Цахим хуудас / цахим шуудан	
СЗХ-ны тусгай зөвшөөрлүүд			
Брокер	Дилер	Андеррайтер	
(дугаар)	(дугаар)	(дугаар)	
МҮЦБ-д элсэхийг хүсэж буй гишүүдийн төрөл			
Андеррайтер	Дилер	Брокер	Зах зээл үүсгэгч
Холбоо барих мэдээлэл			
Ажилтны нэр		Ажилтны утас	
Ажилтны цахим шуудан			

### Маягт 3

#### Гүйцэтгэх захирал болон боловсон хүчний анкет

Огноо: 20\_\_ оны \_\_ сарын \_\_

Ерөнхий мэдээлэл				
Овог:	_____			
Нэр:	_____			
Регистрийн дугаар:	_____			
Хүйс:	<input type="checkbox"/> эрэгтэй <input type="checkbox"/> эмэгтэй			
Албан тушаал:	_____			
Холбоо барих:	_____	Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх үнэмлэхийн:		
И-мэйл хаяг:	_____	Дугаар: _____		
Гар утас:	_____	Авсан он: _____		
Ажлын утас:	_____	Дуусах он: _____		
Боловсрол				
Төгссөн сургууль	Хаана	Мэргэжил	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар
Албан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан жил	Ажлаас гарсан шалтгаан	

\_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нь дээрх мэдээллийг үнэн зөв мэдүүлснийг баталж байна.

Гарын үсэг: \_\_\_\_\_

## Маягт 4

### Гарын үсгийн баталгаа

Огноо:

Хэнд: “Монголын Үнэт Цаасны Бирж”,  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Бээжингийн гудамж  
GB Plaza - 703 тоот

Гишүүний нэр / Member name		Дансны дугаар / Account number	
Овог, Нэр <i>Full name</i>	Регистрийн дугаар <i>Passport or ID number</i>	Албан тушаал <i>Position</i>	Баталгаат гарын үсэг <i>Specimen of authorized signature</i>
<b>1-р гарын үсэг /</b> <i>1st signature</i>			
<b>2-р гарын үсэг /</b> <i>2nd signature</i>			
<b>3-р гарын үсэг /</b> <i>3rd signature</i>			
<b>Гишүүний тамга, тэмдэг дардас /</b> <i>Company stamp</i>		<b>Нотариатын тэмдэглэгээ /</b> <i>Notary verification</i>	

## ХАВСРАЛТ 2

### Гишүүнчлэлийн гэрээний үлгэрчилсэн загвар

Дугаар ....

..... оны .... сарын ...-ны өдөр

Энэ гэрээг

нэг талаас Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бээжингийн гудамж, Жи Би Плаза, 703 тоот хаягт байрлах **Монголын Үнэт Цаасны Бирж ХК** (цаашид “Төв клиринг” гэх) түүнийг төлөөлж **Гүйцэтгэх захирал** албан тушаалтай \_\_\_\_\_;

нөгөө талаас \_\_\_\_\_ дүүрэг, \_\_\_\_\_ дугаар хороо, \_\_\_\_\_, \_\_\_\_\_ тоот хаягт байрлах \_\_\_\_\_ (Улсын бүртгэлийн дугаар: \_\_\_\_\_, регистрийн дугаар: \_\_\_\_\_) түүнийг төлөөлж \_\_\_\_\_ албан тушаалтай \_\_\_\_\_ (цаашид “Гишүүн ҮЦК” гэх) нар байгуулав.

Гишүүн ҮЦК нь энэ гэрээгээр Биржийн гишүүн болохоор харилцан тохиролцов.

#### 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ гэрээгээр Гишүүн ҮЦК Биржийн арилжаанд оролцохтой холбоотой талуудын харилцааг зохицуулна.
- 1.2. Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Биржээс баталсан дүрэм, журмаар зохицуулна.
- 1.3. Энэ гэрээнд ашиглагдсан нэр томъёог Биржийн холбогдох дүрэм, журамд заасны дагуу ойлгоно.

#### 2. ТӨЛӨӨЛӨЛ, БАТАЛГАА

- 2.1. Гишүүн ҮЦК энэ гэрээг байгуулснаар дараах зүйлсийг хүлээн зөвшөөрч баталгаажуулав. Үүнд:
  - (i) Арилжаанд оролцоход шаардлагатай бүхий л тусгай зөвшөөрлийг холбогдох эрх бүхий байгууллагаас авсан, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах эрхтэй хуулийн этгээд болохыг;
  - (ii) Биржийн гишүүнчлэл авч, ҮЦК-ийн холбогдох үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн болон хүний нөөц, техникийн чадамжтай болохыг;
  - (iii) Энэ гэрээг байгуулснаар түүний бусад үйл ажиллагаатай харшлахгүй болохыг.
- 2.2. Энэ гэрээний 2.1-т зааснаас гадна Биржээс баталсан журам, шийдвэрт заасан бүхий л баталгааг гаргана.
- 2.3. Гишүүн ҮЦК энэ гэрээ болон бусад холбогдох журамд заасан баталгааг хангаж чадахгүй болсон тохиолдолд Биржид нэн даруй мэдэгдэнэ.

#### 3. НУУЦЛАЛ

- 3.1. Талууд энэ гэрээний хэрэгжилтийн явцад мэдээллийн нууцлалыг хангаж ажиллана.

- 3.2. Энэ гэрээний хэрэгжилттэй холбоотой хөрөнгө санхүү, ашиг, техникийн холбогдолтой баримт бичиг, мэдээлэл нь нууцлалд хамаарагдах бөгөөд гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.
- 3.3. Энэ гэрээний 3.1. болон 3.2.-т заасныг үл харгалзан Эрх бүхий байгууллагын шийдвэр болон Биржээс баталсан журам, шийдвэрт заасан шалтгаанаар аливаа нууц мэдээллийг бусдад задруулж болно.
- 3.5. Энэхүү гэрээ цуцлагдсан, дуусгавар болсноос хойш талууд нөгөө талын нууц мэдээллийг 3 жил хадгалах үүрэг хүлээнэ.

#### **4. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ДУУСГАВАР БОЛОХ, ЦУЦЛАХ**

- 4.1. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 4.2. Талууд энэ гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд гэрээний хувиуд хууль эрх зүйн хувьд ижил хүчинтэй байна.
- 4.3. Энэ гэрээ нь талуудын хооронд урьд өмнө байгуулсан болон цаашид байгуулах аливаа гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй бөгөөд тэдгээр гэрээ нь мөн энэ гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.
- 4.4. Талууд гэрээний нөгөө талд 1-ээс доошгүй сарын өмнө урьдчилан бичгээр мэдэгдсэнээр энэ гэрээг дуусгавар болгож болно.
- 4.5. Бирж холбогдох журамд заасан үндэслэлээр энэ гэрээг цуцалж болох бөгөөд энэ тухай шийдвэр гарсан даруйд гишүүн ҮЦК-д мэдэгдэнэ.
- 4.6. Энэ гэрээ цуцлагдсан, дуусгавар болсноос хойш ажлын 15 өдрийн дотор талууд хоорондын тооцоог дуусгана.
- 4.7. Энэхүү гэрээний хугацаа дуусахаас ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Гишүүн гэрээг сунгах тухай хүсэлтийг Биржид бичгээр гаргана. Уг хүсэлтийг үндэслэн Бирж гэрээг сунгах асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.8. Гишүүн гэрээ сунгах хүсэлт гаргаагүй, гаргасан боловч холбогдох шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна гэж Бирж үзсэн бол энэхүү гэрээг сунгахгүй.

#### **5. ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

- 5.1. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа үл ойлголцолд Монгол Улсын хүчин төгөлдөр хууль, тогтоомж болон бусад эрх зүйн актуудыг хэрэглэнэ.
- 5.2. Гэрээний талууд гэрээг дагаж мөрдөх явцад үүссэн маргаан, саналын зөрчилдөөнийг харилцан тохиролцож, зөвшилцөх зарчмаар шийдвэрлэнэ.
- 5.3. Талууд зөвшилцөлд хүрээгүй бол тус маргааныг МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрын “Үнэт цаасны маргааныг шийдвэрлэх түргэвчилсэн дүрэм”-ийн дагуу тус арбитраар шийдвэрлүүлнэ. Арбитрын шийдвэр эцсийнх байна.

#### **6. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

- 6.1. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэ гэрээний салшгүй хэсэг байна.
- 6.2. Талууд энэ гэрээнд нэмэлт, эсхүл өөрчлөлт оруулсан бол тухайн нэмэлт, эсхүл өөрчлөлтийг хэрэгжүүлэх болон дуусгавар болгох хугацааг тодорхой заасан байна.

## **7. БУСАД**

- 7.1. Бирж холбогдох журамд заасны дагуу гишүүн ҮЦК-д арилжааны болон шаардлагатай бусад дансыг нээж өгнө.
- 7.2. Гишүүн ҮЦК нь Биржээс баталсан хүчин төгөлдөр журам болон бусад эрх зүйн актыг дагаж мөрдөнө.
- 7.3. Энэхүү гэрээний аль нэг заалт хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон нь бусад заалтын хүчинтэй байдалд нөлөөлөхгүй.
- 7.4. Энэхүү гэрээний эрх үүрэг, өр төлбөр, шаардах эрхийг гэрээний аль нэг тал аливаа гуравдагч этгээдэд зөвхөн нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр шилжүүлнэ. Энэ журмыг зөрчиж эрх үүрэг, өр төлбөр, шаардах эрх шилжүүлсэн аливаа шийдвэр, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

## **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

### **Төв клирингийг төлөөлж:**

Гүйцэтгэх захирал

---

(гарын үсэг)

Хаяг:

Утас:

Цахим шуудан:

### **Гишүүн ҮЦК-ийг төлөөлж:**

Гүйцэтгэх захирал

---

(гарын үсэг)

Хаяг:

Утас:

Цахим шуудан:



**Монголын Үнэт Цаасны Биржийн Гишүүнчлэлийн гэрээний хавсралт****Үйл ажиллагааны төрөл**

Үйл ажиллагааны төрөл	Гэрээ байгуулсан огноо	Үйл ажиллагаа эрхлэх хугацаа	Сунгалт
Брокер			
Дилер			
Андеррайтер			

**Гишүүнчлэлийн хураамжийн хуваарь**

Хураамж	Дүн	Төлөх огноо
Элсэлтийн хураамж	_____ төгрөг	201_/_/_
Жилийн хураамж	_____ төгрөг	201_/_/_
1-р улирлын хураамж	_____ төгрөг	201_/_/_
2-р улирлын хураамж	_____ төгрөг	201_/_/_
3-р улирлын хураамж	_____ төгрөг	201_/_/_
4-р улирлын хураамж	_____ төгрөг	201_/_/_

**Мэдээлэл солилцох**

Биржийн хаяг:	Гишүүний хаяг:
Цахим шуудан:	Цахим шуудан:
Утас:	Утас:
Факс:	Факс:

**Хөнгөлөлт**

Хөнгөлөлт үзүүлэх нөхцөл	Хөнгөлөлт үзүүлэх дүн

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН****Төв клирингийг төлөөлж:**

Гүйцэтгэх захирал

\_\_\_\_\_  
(гарын үсэг)

Хаяг:

Утас:

Цахим шуудан:

**Гишүүн ҮЦК-ийг төлөөлж:**

Гүйцэтгэх захирал

\_\_\_\_\_  
(гарын үсэг)

Хаяг:

Утас:

Цахим шуудан: